



БАЯНХОНГОР АЙМАГ  
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/101

Баянсайр

Сумын хэмжээнд “Архидан согтуурахтай  
тэмцэх сарын аян” зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1, 14.3.2, 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Архидан согтуурахтай тэмцэх сарын аян”-ыг 2022 оны 01 дүгээр сарын 03-наас 2022 оны 01 дүгээр сарын 31 -ны өдрийг хүртэлх хугацаанд архигүй сарын аян зарлан зохион байгуулсугай.

2. “Архидан согтуурахтай тэмцэх сарын аян”-ыг сумын хэмжээнд зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбаням- Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: С.Өлзий-Орших – Хууль, эрх зүйн мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Наранбаатар – Тамгын газрын дарга

Ц.Энхтуяа – ИТХ-ын нарийн бичгийн дарга (зөвшилцснөөр)

Б.Өсөхбаяр–Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч

Э.Балжинням - Хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч

Д.Болормаа – Эрүүл мэндийн төвийн дарга

Г.Насанбаяр – Сургуулийн захирал

Х.Соёл-Эрдэнэ – Соёлын төвийн эрхлэгч

Ч.Энхтуяа – Цэцэрлэгийн эрхлэгч

Багийн Засаг дарга нар

3. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, гудамж, хорооллын хэмжээнд бүх нийтийн үйл хэрэг болгон зохион байгуулж, үр дүнг тооцож тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор сумын

642101249

ажлын хэсэгт ирүүлсэн байхыг багийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. “Архидан согтуурахтай тэмцэх аян”-ны хугацаанд архи согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байхыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад үүрэг болгосугай.

5. Дэлгүүр, худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг өвлийн цагийн хуваарьт шилжүүлж, өглөөний 9.00 цагаас оройн 21.00 цаг хүртэл ажилуулсугай.

6. Захирамжийг худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд танилцуулж сурталчлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч (Б.Өсөхбаяр), Хэв журмын цагдаа дэд ахлагч (Э.Балжинням), Олон нийтийн цагдаа (Б.Доржнямбуу) нарт үүрэг болгосугай.

7. “Архидан согтуурахтай тэмцэх сарын аян”-ы хугацаанд зохион байгуулах ажил арга хэмжээнд идэвхтэй оролцож, хамтран ажиллахыг нийт баг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд уриалсугай.

8. “Архидан согтуурахтай тэмцэх сарын аян”-ы нэгдсэн удирдамжийг боловсруулан батлуулж, сургалт нөлөөллийн ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг 7 хоног тутам Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Б.Бямбаням)-д даалгасугай.

ДАРГА



С.ЭНХТӨР